



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№246 /455/

2022.01.13

Цаг үе, үйл явдал

МӨРДЭСТЭЙ БҮГДИЙН МӨРӨӨДЛИЙН СУРГУУЛЬ МОНГОЛ ЖАНЖДЫН ӨРГӨӨ СУРГУУЛЬ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 30 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ!



Батлан хамгаалахын удирдлагын академи үүсэн байгуулагдаж Монгол Улс дотооддоо цэргийн дээд боловсролтой удирдах албан тушаалын офицер бэлтгэж эхэлсний 30 жилийн ой энэ өдөр тохиож байна.

Эл ойн баярын хуралд Монгол Улсын Засгийн газрын

байгуулан хэрэгжүүлэх хариуцлагатай үйлст үнэтэй хувь нэмэр оруулж байгаагийн зэрэгцээ дэлхийн халуун цэгтэнхийг сахиулах ариун үйлсэд үүрэг гүйцэтгэн академийнхаа нэр хүндийг өндөрт өргөж явааг онцлоод БХУА-ийн сургалтын орчин, сургалт, эрдэм шинжилгээний ажлыг явуулах таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний

гэлээ.

Арга хэмжээний төгсгөлд үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх, төрийн цэргийн байгууллагын "Стратеги-тактик, цэргийн удирдлага" мэргэжилтэй удирдах албан тушаалтнуудыг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх, цэргийн дээд боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлэн

сургаж бэлтгэх үүрэгтэй байгуулагдсан "Оперативын факультет" өнгөрсөн 30 жилийн хугацаанд сургалтын агуулга технологи, багшлах боловсон хүчин, материаллаг баазын хувьд жилээс жилд хөгжин дэвшсээр өдгөө үндэсний хэмжээнд цэргийн дээд боловсролтой офицер, удирдах албан тушаалтныг бэлтгэдэг цэргийн академи болтлоо өргөжсөн байна.



гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын сайдын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Дашзэвэг, ҮБХИС-ын захирал бригадын генерал П.Жаргалан, ХХЕГ-ын дарга, Хилийн цэргийн командлагч, бригадын генерал Х.Лхагвасүрэн, БХУА-ийн захирал бригадын генерал Л.Онцгойбаяр тэргүүтэй ҮАБЗ, БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн байгууллагуудын удирдлага, Төрийн цэргийн командлагчид, БХУА-ийн үе үеийн захирлууд, ахмадууд, төгсөгчдийн төлөөлөл оролцож байна.

Хүндэтгэлийн баярын хурлыг нээж БХУА-ийн захирал бригадын генерал Л.Онцгойбаяр хэлсэн үгэндээ манай академийн төгсөгчид БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, Дотоодын цэрэг, ОБЕГ, ШШГЕГ-ын удирдах албан тушаалуудад амжилттай ажиллаж, Батлан хамгаалах салбарын шинэчлэлтийг гардан зохион

Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нарт академийн хамт олны нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлсэн юм.

Үүний дараа Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БХУА-ийн 30 жилийн ойд зориулж мэндчилгээ дэвшүүлсэн юм. Тэрээр хэлсэн үгэндээ "Цэргийн шинэчлэлт, өөрчлөлтийн агуулгад орших Цэргийн номлол, зэвсэгт тэмцэл явуулах стратеги-тактикийн үндсийг тодотгох, цэргийн сургалт, бэлтгэлийн тогтолцоог шинэчлэх, Зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоох зэргээс гадна Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чадварлаг хүний нөөцөөр хангах, даргалах бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, бүрдүүлэх нь өнөө цагт анхаарах чухал асуудлуудын нэг болоод байна. Иймд БХЯ-ны зүгээс тус академийн сургалтын чанарыг ахиулах, элсэлтийн журамд өөрчлөлт оруулах, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан цэргийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх зэрэг үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжин ажиллах болно"

бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа ҮБХИС-ийн БХУА-ийн зарим тэргүүний багш, ажилтан, алба хаагч, ахмадуудыг Батлан хамгаалах салбарын болон ХХЕГ-ын шагналаар шагнаж урамшууллаа.

Анх Зэвсэгт хүчинд цэргийн дээд боловсролтой стратеги тактик-команд штабын мэргэжил бүхий боловсон хүчнийг

Тус академи нь 1993 оноос өдийг хүртэл хугацаанд боловсролын зэрэг олгох сургалтаар 310, албан тушаалын болон мэргэшүүлэх сургалтаар 1057, БНХАУ-ын дөрөв, БНСУ-ын хоёр нийт 1373 офицер-тактикийн дээд боловсролтой офицерыг бэлтгэн гаргажээ.

Ө.НАСАНТОГТОХ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-24	-39

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.477	3.483
EUR	3.760	3.795
CNY	514.50	517.80
RUB	49.30	50
JPY	26.75	27.10
KRW	2.88	2.90

ЗУРХАЙ



2022.01.13 / БААСАН ГАРАГ /

БИЛГИЙН ТООЛЛЫН 21

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

08.38-17.23

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 670,393,049

Эдгэрсэн

Нийт: 641,572,694

Нас барсан

Нийт: 6,724,256

Цахим шууданд

БАЙЛДАГЧ Н.БАТТАМИР: ОХИНДОО ДАНГИНА ГЭДЭГ НЭР ХАЙРЛАСАН



БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Нямсүрэнгийн Баттамир саяхан аав болжээ. Цээж дүүрэн баярт мэдээтэй, хөл нь газар хүрэхгүй хөөрч яваа байлдагч Дорнод аймгийн

Баяндун сумын харьяат бол түүний хань Ц.Уранболор тус аймгийн Цагаан-Овоо сумынх. Тангаргийн баяраар ангийнхаа соёлын төвийн тайзан дээр дуулж байхдаа эхнэрээ, охиноо олж харсан агшин хамгийн мартагдашгүй мөч гэж ярилцлагынхаа эхэнд хуваалцав. Охиндоо Дангина гэдэг нэр хайрласан,

аав, ээжийнх нь аль аль талаасаа буриад зон олон учир тийнхүү нэрлэжээ.

Тэрээр 2018-2022 онд Хөдөө Аж ахуйн Их сургуульд малын их эмч мэргэжлээр суралцаж төгссөн, төгсөөд нутагтаа аав, ээждээ тусалж байгаад цэргийн албанд татагджээ. Халагдаж очоод ч аав Н.Нямсүрэн, ээж Д.Одсүрэн нартайгаа айлсан бууж, мал маллах ачааг нь үүрч, айлын отгон хүүгийн ёсоор эцэг, эхийнхээ нөмөр, нөөлөг нь болж явна гэнэ. Малын эмч мэргэжлээ амьдрал дээрээ улам туршлагажуулах нь түүний зорилгын нэг.

Байлдагч Н.Баттамир нь олон төрлийн авьяастай залуу байна. Сагсан бөмбөг, волейбол тоглодог, төрөл бүрийн дуу тэр дундаа зохиолын дууг сайхан дуулчихдаг гэнэ. Зэвсэгт хүчний 327 дугаар анги, Хилийн цэргийн 0132 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд явагдсан спорт өдөрлөгт онжавуудтайгаа хамтдаа тэргүүлж, бас цэргийн тангаргийн баяраар ая дууны мэндчилгээ өргөж зогсохдоо охиноо олж харсан нь тэр ажээ. Цэрэгт сумаасаа 10-уулаа ирсэн, олонх нь дүү нар бөгөөд өөрийгөө онжавууд дотроо магад "хөгшин" цэрэгт тооцогдох байх гэж инээгээд "Цэргийн албанд ирснээр зан төлөвшил, хувийн зохион байгуулалт орчноо дагаад өөрчлөгдөж байна. Олон найз нөхөдтэй болж, тэдний адил үлгэрлэл, манлайлагч байхыг хичээх нь өөрийгөө хөгжүүлэх



хөшүүрэг нь болов. Цэргийн тангараг өргөхөөс өмнө өндөр ачаалалтай байсан бол түүнээс хойш цагийн хуваарийн дагуу явагдаад, бүгд жигдэрчихдэг юм байна" гэлээ.

Түүний гэргий Ц.Уранболортой цахимаар холбогдож сэтгэгдлийг нь хуваалцахад "Манай хань цэргийн албанд хүсэн мөрөөдсөөр байгаад явсан. Олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцэн цог золбоо дүүрэн

гүйж явааг нь хараад хараад бахархсан шүү. Үнэхээр л эр хүн бүрийн хаах ёстой алба юм байна гэдгийг Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хашаанаас мэдэрсэн. Үргэлж шинийг суралцах хүсэл тэмүүлэл дүүрэн байдаг болохоор цэргийн албанаас их зүйлийг сурч мэднэ гэдэгт нь итгэлтэй байна. Охин бид хоёр аавыгаа цэргээс ирэхэд нь бахархал дүүрэн угтах болно оо" гэсэн юм.

ШИЛДЭГ ЭШЛЭЛИЙН ЭЗЭД ТОДОРЛОО



ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн дэргэдэх "EXIT UP" эрдэм шинжилгээ судалгааны клубээс зохион байгуулсан "Өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудал ба бидний оролцоо" сэдэвт эшлэлийн уралдааны шилдгүүд тодорлоо.

Тус эшлэлийн уралдаанд нийт 50 гаруй оюутан залуус оюун ухаанаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт АБДС-ийн оюутан Н.Хосбаяр, дэд байрт АБДС-ийн оюутан Б.Ариунжаргал, гутгаар байрт АБДС-ийн оюутан Б.Энхбаясгалан, шагналт байрт МУБИС-ийн оюутан М.Сарнай, АБДС-ийн оюутан Б.Алтаншагай нар тус тус шалгарчээ.

Мөн энэ үеэр тусгай номинациудыг шалгаруулсан бөгөөд "Хамгийн олон хүнд хүрсэн эшлэл"-ийн төрөлд АБДС-ийн оюутан Б.Гэрэлт-Од, "Хамгийн онч мэргэн эшлэл"-ийн төрөлд ДХИС-ийн сонсогч У.Дэчинпүрэв, "Хамгийн өвөрмөц эшлэл"-ийн төрөлд Эрдэнэт хотын 13 дугаар сургуулийн сурагч Н.Лхагва тэргүүлээ.



Зарлал

ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН СУРГАЛТ ЯВАГДАХ ГЭЖ БАЙНА

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын тушаалаар Батлан хамгаалах салбарын цэргийн инженерийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, магадлан итгэмжлэх зөвлөл байгуулагдаж тус зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, журам шинэчлэн батлагдлаа.

ҮБХИС-ийн ЦНДС-ийн Цэргийн инженер, химийн тэнхим, "Инженерийн цэргийн холбоо" ТББ хамтран мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Иймд мэргэшлийн зэрэг горилочид дэлгэрэнгүй мэдээллийг /ҮБХИС-ийн <http://mndu.gov.mn> сайт болон 88076595, 99896595 дугаарт/ холбогдож авна уу.

Жич: Бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүрдүүлж ирнэ үү

- Үүнд:
1. Зэрэг горилохыг хүссэн хувийн өргөдөл: Өргөдөлийг батлагдсан маягтаар гаргана. /Өргөдөлийн маягтыг нэгдүгээр хавсралтаар гаргана/
 2. Ажил байдлын тодорхойлолт: Тодорхойлолтыг тухайн хүний үндсэн байгууллагаас тодорхойлж, удирдлага нь гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Шаардлагатай гэж үзвэл харъяалагдах дээд байгууллагын тодорхойлолт гаргаж болно.
 3. 3x4 хэмжээтэй 2 хувь зураг/файлаар/
 4. Дээд боловсролын үнэмлэх, дипломын хуулбар: Дээд боловсролын үнэмлэх, дипломын хуулбарыг нотариатаар баталгаажуулах, хэрэв баталгаажуулаагүй бол хуулбарыг эхтэй нь тулгаж хүлээж авна. /Гадаадад зэрэг хамгаалсан бол орчуулгын товчоогоор орчуулуулж, баталгаажуулсан байх/
 5. Бүтээлийн тайлан, жагсаалт: Бүтээлийн тайлан жагсаалтыг үндсэн байгууллагын удирдах ажилтан ба зөвлөх зэрэгтэй хоёроос доошгүй мэргэжилтэн хянаж баталгаажуулсан байна. Бүтээлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар гаргана. /Хүснэгтийн загвар доор бий/
 6. Иргэний үнэмлэхний хуулбар/баталгаажуулсан байна/
 7. Сургалт шалгаруулалттай холбогдсон төлбөрийн баримт: Төлбөрийг бэлнээр буюу дансаар төлж болно.

Гэрэл зургийн фондоос



Даян дэлхийн улс орнуудтай хаяа дэрлэн энх тайвнаар зэрэгцэн оршиж буй Монгол Улсын энхийг эрхэмлэсэн олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд манай энхийг сахиулагчдын хувь нэмэр, гүйцэтгэж буй үүрэг үлэмж их билээ.